



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А48

Хэрлэн сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын 2009 оны 348 дугаар тогтоол болон "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд "Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх" ажил хэрэгжсэнтэй холбогдуулан 2 төрийн байгууллагуудад 1 дүгээр хавсралтад заагдсан газрыг эзэмшүүлсүгэй.

2. Төрийн байгууллагуудын газрын эзэмшиж байгаа газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг хавсралтад дурдсан байгууллагуудад даалгасугай

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2007 оны 332 дугаар захирамжийн 7 дугаар хэсгийг, 2008 оны 2(9 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА



01 Аймгийн Засаг даргын 2019 оны
дүгээр сарын 24 өдрийн
дугаар захирамжийн хавсралт



**ХЭРЛЭН СУМАНД ГАЗАР ЭЗЭМШИЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГЫН ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ**

д/д	Иргэний эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр	Регистрийн дугаар	Хуучин талбайн хэмжээ /м ² /	Талбайн хэмжээ /м ² /	Байршил	Газар эзэмшлийн зориулалт	Хугацаа /жил/
1	Нийтийн номын сан	4185463	1935	1379	3-р баг Залуучуудын гудамж Д-03 тсйт	Төрийн байгууллага	49
2	"Хэрлэн дом" өрхийн эрүүл мэндийн төв	2162342	347	762	1-р баг Тэмүүжингийн гудамж Ж-19 тоот	Төрийн байгууллага	48